



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/214

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа М.Энх-Амараар ахлуулсан Шуурхай бүлэг Ховд аймагт ажиллаж хаваржилтын нөхцөл байдалтай танилцсаны үндсэн дээр өвс тэжээлийг хямдралтай үнээр олгох, зарим сумдын түргэн тусламжийн авто машины асуудлыг газар дээр нь шийдвэрлэж орон нутагт ажилласан зардалд 3 853 750 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 853 750 төгрөг /Гурван сая найман зуун тавин гурван мянга долоон зуун тавин/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас хамгаалах зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/214 Ch
02 01034